



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2010 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

Г Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол банкны захиалгаар Данзанбалжирын¹ Энхжаргалыг Английн Лондонгийн их сургуулийн докторантурт Санхүү эдийн засгийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Зулькафилийн² Серикийг Английн Суссикийн их сургуулийн докторантурт Социолгоийн чиглэлээр 3 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны захиалгаар Найдангийн³ Билгүүнийг АНУ-ын Миссурийн их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Гадаад харилцааны яамны захиалгаар Самбуугийн⁴ Даваадашийг АНУ-ын Тафтс их сургуулийн магистрантурт Олон улсын харилцааны чиглэлээр 2 жилийн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар Энхбаатарын⁵ Тэмүгэг АНУ-ын Массачусетийн технологийн их сургуулийн бакалаварт Биотехнолгийн чиглэлээр 2 жилийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Жамъяансэнгээгийн⁶ Эрдэнэболдыг Австралийн Валийн их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр 2 жилийн, Монгол банкны захиалгаар Очбадрахын⁷ Энхсаруулыг Австралийн Валийн их сургуулийн магистрантурт Банкны чиглэлээр 2 жилийн, Боловсрол, сёл, шинжлэх ухааны захиалгаар Чимэдцэрэнгийн⁸ Нандинтуяаг Английн Эксетрийн их сургуулийн магистрантурт Санхүү, эдийн засгийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Сүхбалтын⁹ Нандинтуяаг Бүгд Найрамдах Солонгос Улсын Тээгүү хотын их сургуулийн бакалаварт Багш-арга зүйчийн чиглэлээр 2 жилийн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар¹⁰ Амгаланбаатарын Ганбаатарыг АНУ-ын Индианагийн их сургуулийн магистрантурт Эрх зүйн чиглэлээр 2 жилийн, Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар Шагдаржавын Чинбатыг АНУ-ын Врижины их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Сангийн яамны захиалгаар Сосорбарамын¹¹ Наранхүүг Австрали Улсын Мельбурний их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар Канадын Монериалын Бизнесийн удирдлагын дээд сургуулийн бакалаврт Бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй Алтангэрэлийн Солонгын суралцах хугацааг 2 жилээр сунгасугай.


2.

3. Английн Кембрижийн их сургуулийн докторантурт Байгалийн ухааны чиглэлээр суралцаж буй Тэрбишийн Баасанжавын сүүлийн 2 жилийн зардлыг Сургалтын сангийн зээлд хамруулсугай.

4. Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Москвагийн их сургуулийн аспирантурын төгсөх ангийн адъюнкт, цагдаагийн хурандаа Төмөр овогтой Бямбаа, Дотоод явдлын яамны Санкт-Петербургийн их сургуулийн аспирантурын төгсөх ангийн адъюнкт, цагдаагийн хошууч Нийдэн овогтой Ганбаатар нарт эрдэм шинжилгээний хамгаалалтын зардалд шаардагдах санхүүжилтийг олгосугай.

5. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



[Handwritten signature]

Ё.ОТГОНБАЯР